

413 95



НИЙСЛЭЛИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ХОРООНЫ ДАРГЫН ТУШААЛ

2008 оны 06 сарын 06 өдөр

Дугаар 39

Улаанбаатар хот


ӨМЧИЙН ҮЗЛЭГ, ТООЛЛОГО ЯВУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 167 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2008 оны 239 дүгээр захирамжийг тус тус үндэслэн **ТУШААХ НЬ**:

Нэг. Нийслэлийн өмчийн үзлэг, тооллогыг удирдан зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнийг дор дурдсанаар баталсугай. Үүнд:

Комиссын ахлагч	А.Болдмаа /ахлах мэргэжилтэн/
Гишүүд	Н.Өлзийжаргал /мэргэжилтэн/ О.Болор-Эрдэнэ /мэргэжилтэн/

Хоёр. Байгууллагын өмчийн эд хөрөнгийн Улсын үзлэг, тооллогын ажлыг Төрийн өмчийн хорооны 2008 оны 282 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн болон орон нутгийн өмчийн тооллого явуулах журам, заавар, аргачлалыг удирдлага болгон 2007 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн тайлангийн дүнгээр тасалбар болгон 2008 оны 06 дугаар сарын 13-ны дотор багтаан явуулахыг Тооллогын комисс /А.Болдмаа/-т даалгасугай.



ДАРГА

Ж.ГАНБОЛД

050088